



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТИН ГАЗАР

АЛБАН ШААРДЛАГА

2017 оны 06 сарын 06 өдөр

Дугвар 33

Номгон

## Г ЗЭРЧИЛ АРИЛГУУЛАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлд тодорхойлсон Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сангийн зээлийн хуваарилалт, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитаар дараах зерчил илэрлээ. Үүнд:

Орон нутгийн ЖДУ "Эрхлэгчдийг дэмжиж хөнгөлөлттэй зээл олгох зорилгоор 2007-2009 онд орон нутгийн орлогоос аймгийн Засаг дарга, Хас банкны захиралтай байгуулсан хамтран ажиллах гэрээний дагуу Хас банкин дахь Тусгай санд байршуулсан нийт 75,0 сая төгрөгийг аймгийн Төсвийн Ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайландаа тусгаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4.2-т "бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлагыг Нягтлан бодох бүртгэлд заавал бүртгэнэ" гэсэн заалтуудыг зерчсон байна.

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоо, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 4 дугаар зүйлийн 4.1.1-д засан "Нягтлан бодох бүртгэлийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, холбогдох стандарт, журам, шаардлагын дагуу зохих ёсоор хөтлөөгүй" гэсэн заалтуудыг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Аймгийн орон нутгийн орлогоос Хас банкин дахь Тусгай санд байршуулсан нийт 75,0 сая төгрөгийг аймгийн Төсвийн Ерөнхийлөн захирагчын санхүүгийн нэгтгэсэн тайландаа авлагаар бүртгэх.

2517035

2. Албан шаардлагын биелэлтийг 2017 оны 6 дугаар сарын 30-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Баянхонгор аймгийн ЗДТГ-ын Санхүү, Төрийн сангийн хэлтсийн дарга С.Байгалмаа, ерөнхий нягтлан бодогч Ц.Самбууням нарт хариуцуулав.

**АЛБАН ШААРДЛАГЫГ:**

**ӨГСӨН:**

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН  
АУДИТЫН ГАЗРЫН АХЛАХ  
АУДИТОР А.ЦЭЭНЯМ  
АУДИТОР М.АЛТАНТУЯА  
АУДИТОР Б.АЗБАЯР

**ЗӨВШӨӨРСӨН:**

АЙМГИЙН ЗДТГ-ЫН СТСХ-ИЙН  
ДАРГА С.БАЙГАЛМАА  
ЕРӨНХИЙ НЯГЛАН БОДОГЧ  
Ц.САМБУУНИЯМ

1. Акт, албан шаардлагын биелэлт ханаагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-д заасан "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлзээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага ногдуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.